

ПОЛИГРАФОЛОГИ БА СЭТГЭЦ ФИЗИОЛОГИЙН МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ШИНЖ ЧАНАР POLYGRAPH AND PSYCHO-PHYSIOLOGICAL INFORMATION



Ж.Болдбаатар. ХСИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа
J.Boldbaatar. Dean of Research of the Law Enforcement University, Sc.D, Professor, Police colonel

Abstract: Polygraph is used in many branches including law enforcement. Specially, practice shows its effectiveness for crime detection.

Амьд байгальд орших хамгийн нарийн нийлмэл бүтэц, үйл ажиллагаа бүхий бодгаль болох хүн нь түүнийг хүрээлэн буй орчин биосфер²⁴⁷, ноосфер²⁴⁸ - тэй байнга харилцан шүтэлцээнд байх бөгөөд танин мэдэхүйн хялбар бус судлагдахуун билээ. Байгаль, нийгмийн орчинд үүсэн бий болж хөгжихийн сацуу, эдгээрийг зангидаж, өөрчилж байдаг өвөрмөц тогтолцооны хувьд хүн, түүний бие организм, үйл ажиллагаа янз бүрийн мэдлэгийн салбарын зангилаа асуудал байсаар ирэв.

Сүүлийн жилүүдэд шинжлэх ухаан, техник, технологийн үсрэнгүй хөгжлийн үр дүнд хүний дээд мэдрэлийн үйл ажиллагааг судлах, сэтгэл хөдлөлийн түвшинг тодорхойлох, түүнд үнэлгээ өгөх шинэ шинэ арга анагаах ухаан, сэтгэц судлал, хууль зүй, техникийн мэдлэгийн салбарт хурдацтайгаар нэвтэрч байна. Хүний сэтгэц физиологийн шинж байдлын талаар мэдээлэл цуглуулах зорилгоор авир араншин, сэтгэл хөдлөл, бие махбодийн үйл ажиллагааг нь олон талын шалгуур үзүүлэлтээр бүртгэн дүгнэж, эрх зүй ба ёс зүйн хүрээний зарим асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж буй "Полиграфологи" хэмээх мэдлэгийн тогтолцоо эрчимтэй хөгжиж байна.

"Полиграфологи" гэх шинжлэх ухааны нэршил нь грек хэлний ("polis"-олон; "grapho"-бичиж байна; "logus"-судлахуй) гэсэн үгсээс үүсэлтэй ба "олон бичлэгийг судлахуй" хэмээн түүнийг утгачилж болох бөгөөд дээрх нэр томъёогоор хүний сэтгэц физиологийн хариу урвалыг техникийн

тусламжтайгаар бүртгэн мэдээлэл цуглуулах зүй тогтлыг судалдаг мэдлэгийн тогтолцоог илэрхийлж хэвшээд байна.

Харин "Полиграф"²⁴⁹ хэмээх нэр томъёогоор ийнхүү "олон бичвэр" үйлдэх арга зүйн тогтолцоог бүхэлд нь нэрлэж байна. Шинжлэх ухааны өргөн агууламж бүхий, олон элементийн цогцоос бүрдэх мэдлэгийг зөвхөн "полиграф" хэмээх нэр томъёогоор илэрхийлэх нь төдийлөн оновчтой бус бөгөөд полиграфологийн мэдлэгийн салбарт түгээмэл хэрэглэдэг ойлголт, нэр томъёо зэргийг цэгцлэх, хууль зүй, сэтгэц судлал, эрүүл мэнд, техникийн шинжлэх ухааны үүднээс тэдгээрийг нэг мөр ойлгох, онол-практикийн хүрээний тодорхой асуудлыг оновчтой томъёолох, цаашид уг мэдлэгийн тогтолцоог бүхэлд нь хөгжүүлэх зорилгоор "полиграфологи", "полиграфын сорил зүй", "полиграфын онош зүй", "полиграфын мэдээлэл зүй", "полиграфын арга зүй", "полиграфын тактик зүй", "полиграфын шинжилгээ зүй" зэрэг шинжлэх ухааны агууламж бүхий олон ухагдахууныг бий болгон тодорхойлох шаардлага байгаа нь харагддаг.

Сүүлийн жилүүдэд "Криминалистикийн полиграфологи" хэмээх нэрийн дор гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагааны үед хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох зорилгоор полиграф төхөөрөмж ашиглах арга, барил, хэрэгслийг судалдаг полиграфологийн мэдлэгийн дэд салбар бодитойгоор бий болоод байна.

²⁴⁷ Биосфер- амьд байгаль

²⁴⁸ Ноосфер- хүний нийгэм

²⁴⁹ Полиграф (олон бичвэр)-ыг мөн "вариограф", "плетизмограф" гэж нэрлэх нь бий.

Криминалистикийн полиграфологиюг “сэжигтний сэтгэц-физиологийн байдлыг үгэн өдөөгч болон багажийн тусламжтайгаар тодорхойлох арга судлал”²⁵⁰ гэж үзээд, шинжлэх ухаанч мэдлэгийн тогтолцооных нь хувьд хүлээн зөвшөөрч, гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах практикт өргөн ашиглахыг мэргэжилтнүүд зөвлөдөг.

Полиграфологийн мэдлэгийг зөвхөн гэмт хэрэг илрүүлэх, хэргийн бодит үнэнийг тогтооход ашигладаггүй. Цагдаа, тагнуул зэрэг төрийн тусгай албад хүний нөөцөө сонгох, тангарагтаа үнэнч байгаа эсэхийг шалгах, тодорхой үүрэг гүйцэтгэх чадвартай, хортой зуршилд автсан эсэхийг тодорхойлох зэрэгт өргөн ашигладаг. Энэ нь “Албаны полиграфологи” хэмээх полиграфологийн мэдлэгийн дэд салбар мөн хөгжиж буйг илтгэж буй баримт мөн.

Судлаачид “полиграф”-ыг янз бүрээр тодорхойлж ирсэн бөгөөд хүний амьсгалах болон зүрхний лугших хэм, судасны цохилт, арьсны мэдрэмж, цусны даралт зэрэг физиологийн шинж илүү тод илэрдэг биеийн эмзэг хэсгүүд болох хацар, дух, алга, хэвлий, цээж зэрэгт бүртгэх хэрэгслийн хүлээн авуурыг (receptor) байрлуулан, түүгээр дамжих мэдээллийг бичигч хэрэгслийн (бичүүр) тусламжтайгаар “полиграмм”²⁵¹ хэлбэрт оруулан бэхжүүлэн авч, түүнийгээ задлан шинжлэх замаар ярилцагчийн сэтгэц физиологид гарсан өөрчлөлтөд үнэлгээ өгөх нь полиграфологийн мөн чанар болж байна.²⁵²

Полиграфологи буюу полиграф зүй нь физиологийн шинжлэх ухаан, сэтгэц судлалын шинжлэх ухаан, техникийн шинжлэх ухаан, хууль зүйн шинжлэх ухааны уулзварт оршиж буй танин мэдэхүйн салбар мөн. Тийм болохоор эдгээр болон бусад шинжлэх ухааны хүрээнд бий болсон мэдлэгийн тогтолцоо нь полиграфологиюг бий болгон хөгжүүлэх, түүний мэдлэгийг гэмт хэрэгтэй тэмцэх практикт ашиглах шинжлэх ухааны үндэслэл, онолын хөрс суурь нь болж байдаг онцлогтой.

Хууль бус аливаа үйлдэл болон ийм үйлдлийн тухай мэдээлэл нь хүний мэдрэл-сэтгэхүйд тусгал хэлбэрээр үлдэж, тодорхой нөхцөл үүсгэх үед сэтгэц физиологийн нэлээд үзүүлэлтэд, тухайлбал, судасны лугшилт, амьсгалын хэмнэл, хялгасан судасны цусан хангамж, артерын даралтын болон үйл хөдлөлийн өөрчлөлт гэх мэтэд нөлөөлдөг гэсэн таамаглал нь полиграфологиюг ашиглах шинжлэх ухааны ерөнхий үндэслэл болно.

Ярилцлагын үед асуултын агуулга тухайн хүнд чухал байх тусам бэхжүүлэн авч буй сэтгэц физиологийн хариу урвал илүү тод илрэх магадлал өндөр байдаг. Өөрөөр хэлбэл, болж өнгөрсөн үйл

явдлаас мэдрэл-сэтгэхүйд тусгал хэлбэрээр үлдсэн сэтгэл хөдлөлийн тэр содон мэдээллийг хожим хүн санах (эсвэл сануулах) үед түүний хүсэл зоригоос үл хамааран физиологийн үйл ажиллагааны аль нэг системд заавал өөрчлөлт ажиглагддаг зүй тогтолтой.

Полиграф ашиглан хийх ярилцлагын үр дүн нь асуултын агуулга, чанараас шууд хамааралтай бөгөөд түүнийг урьдчилан боловсруулах зорилго нь бэлтгэсэн асуултууд гэмт хэргийн тухай мэдээллийг ямар нэгэн хэмжээгээр агуулж байгаагийн хувьд асуугдагчийг цочроож, түүний сэтгэц физиологийн үзүүлэлтүүдэд мэдэгдэхүйц өөрчлөлт оруулахуйц байхад оршино. Тиймээс полиграф аргыг ашиглан ярилцах үед асуултын жагсаалтыг урьдчилан сайтар боловсруулах асуудал хамгийн гол зүйлийн нэг байдаг.²⁵³

Полиграфологийн техникийн шинжлэх ухааны үндэслэл.

Мэргэжилтнүүд полиграфыг “худлыг илчлэгч” хэрэгсэл гэж үзэхээс илүүтэйгээр, гэмт хэргийн холбогдолтой нууцалж буй мэдээлэл илрэхээс эмээж, үүнээс үүдэлтэйгээр ярилцагчийн бие организмд сэтгэц хямрал (стресс)-ын төлөв байдал үүссэнийг илтгэх, эсвэл ийм мэдээлэл байхгүй учир стрессийн байдалд ороогүйг илтгэх сэтгэц физиологийн хариу урвалуудыг тусгай багажийн тусламжтайгаар бүртгэн авч, харьцуулан шинжлэх зориулалттай төхөөрөмж гэж үздэг.

Ер нь полиграф төхөөрөмж нь ярилцлагын үед физиологийн хариу урвалыг бүртгэх, түүнд зарим үнэлгээ өгөх хэрэгсэл юм. Полиграф ашиглан ярилцах зарчим нь ямар нэгэн мэдээллийг нууж байгаа хүн сэтгэлийн зовиурт автаж явдаг бөгөөд тэр нь ярилцлагын үед (артерын даралт, судасны лугшилт, амьсгалын давтамж болон хэмд өөрчлөлт орох гэх мэт) бие махбодийн хариу урвалаар, ухамсарт захирагдалгүйгээр илэрдэгт оршино.

Гэмт хэргийн холбогдолтой зохих мэдээлэл бүхий хүнтэй полиграф төхөөрөмж ашиглан ярилцах үед сэтгэц физиологийн хариу урвал идэвхжих бөгөөд түүнийг тухайн төхөөрөмжийн тусламжтайгаар бэхжүүлэн авч болох зүй тогтол нь уг аргыг ашиглах техникийн шинжлэх ухааны үндэслэл нь болдог.

Полиграф төхөөрөмж нь хүний биед шууд хүрэлцэн мэдээлэл дамжуулах ангилалд хамаарах техникийн хэрэгсэл бөгөөд мөн чанартаа сэтгэл хөөрлийн улмаас хүний бие махбодид бий болж буй өөрчлөлтийг бүртгэх чадвар бүхий анагаах ухааны зориулалтаар голлон ашиглахаар бүтээгдсэн хэлбэлзэл зүйн бичүүр (осцилограф) багаж мөн. Хүний сэтгэц физиологийн төрөл бүрийн үзүүлэлтийг бүртгэн авах чадвар бүхий мэдрэгчийг биеийн тодорхой цэгүүдэд шууд байрлуулан, мэдээллийг ил

²⁵⁰ Б.Бат-Эрдэнэ. Криминалистик (Лекцүүд), УБ., 2003. 105-106 дахь тал.

²⁵¹ “Полиграмм”- (gramma- зураас, үсэг)- “олон бичвэр”

²⁵² Временные методические указания по проведению опроса граждан с использованием полиграфа //Использование полиграфных устройств в органах внутренних дел //Под ред. А. И. Скрыпникова. М.: ВНИИ МВД РФ, 1996. С. 46.

²⁵³ Скрыпников А.И., Варламов В.А., Зубрилова И.С., Богданова Т.С. Применение полиграфа в оперативно-розыскной деятельности органов внутренних дел России. Методическое пособие. М.: ВНИИ МВД РФ, 1995. С. 25-26.

тод бэхжүүлж авдаг тул сэтгэц хямралын байдлыг зайнаас тодорхойлогч анагаах ухааны бусад хэрэгслээс полиграф төхөөрөмж ялгаатай.

Полиграф төхөөрөмжийг технологийн хувьд бэхээр бичигч болон компьютер гэж ангилна. Бэхээр бичигч полиграф төхөөрөмж нь асуулгад оролцогчийн биеийн тодорхой цэгүүдэд байрлуулсан мэдрэгчээс хүлээн авч буй, уг хүний сэтгэц физиологийн хариу урвалын бүтцийг заагч мэдээллийг тусгай бичигч үзэгний тусламжтайгаар, үл тасалдах муруй дүрс үүсгэн, зугуухан хөдлөх туузан цаасан дээр бэхжүүлэн авах технологид суурилсан бөгөөд полиграмм буюу зэрэгцээ, олон хэмжээст бичлэгийг мэргэжилтнүүд тайлж унших шаардлагатай болдог.

Компьютерийн полиграф төхөөрөмж нь компьютер, мэдрэгч, хэвлэгчээс бүрдэнэ. Мэдрэгчийн хүлээн авч дамжуулсан мэдээллийг процессор боловсруулан, дэлгэц дээр дүрс болгон харуулах ба үүнийг хэвлэгчийн тусламжтайгаар цаасанд буулган авна. Компьютерийн полиграфыг дүн шинжилгээ хийх боломж олгож буй түвшинээр нь автомат ба автомат бус ажиллагаатай хэмээн ангилна.

Автомат бус полиграф төхөөрөмж нь ярилцлагад оролцогчийн сэтгэц физиологийн хариу урвалын илэрцийг зөвхөн муруй шугам хэлбэрээр бүртгэж авах боломж олгодог бөгөөд мэргэжилтэн энэхүү бичлэгийг биечлэн уншиж, дүн шинжилгээ хийнэ. Автомат бус төхөөрөмж нь хүний хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байдаг тул субъектив шинжтэй алдаа гарах магадлалтай.

Компьютерийн автомат полиграф төхөөрөмж нь ярилцлагад оролцогчийн бие организм дахь өөрчлөлтийг муруй шугам хэлбэрээр дүрслэн харуулахын зэрэгцээ сэтгэц физиологийн хариу урвалын илэрцийг нь автоматаар боловсруулан, хүснэгтэн мэдээлэл хэлбэрээр үзүүлдэг давуу талтай. Энэхүү хүснэгтэн мэдээллээс ярилцлагад оролцогчийн сэтгэц физиологийн хариу урвал дахь хэвийн хэмжээнээс хазайсан үзүүлэлт зэргийг харж болно.

Анагаахын шинжлэх ухаанд ашиглаж буй бие организм дахь эмгэг өөрчлөлтийг тандан мэдрэх орчин үеийн төхөөрөмж нь хүний сэтгэц физиологийн байдлыг 32 хүртэл үзүүлэлтээр бүртгэн, дүн шинжилгээ хийх боломж олгодог хэдий ч, бидний судалгаагаар, гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх практикт 3–5 үзүүлэлтээр бичлэг хийх полиграф төхөөрөмжийг голлон ашиглаж байна.

Америкийн полиграфчдын холбооноос: “Гурваас цөөнгүй сувгийн үзүүлэлт бүхий мэдрэгчтэй төхөөрөмжөөр, ярилцлагад оролцогчид ил тод хийж буй үйлдлийг полиграф ажиллагаа гэнэ” хэмээн тогтоож өгсөн ба дээрх 3 үзүүлэлтийн хоёр нь амьсгал болон зүрхний агшилтын давтамжийг (ЗАД) заагч байх ёстой гэж журамлажээ.²⁵⁴

²⁵⁴ Скрыпников А.И., Варламов В.А. нар. Дурьдсан бүтээл. 25-

Харин ОХУ зэрэг зарим улсад таван үзүүлэлтэд түшиглэн, хүний сэтгэц физиологийн байдалд дүн шинжилгээ хийх нь субъектив шинжтэй алдааг багасгах, бодит үнэлгээ өгөх ач холбогдолтой гэж үздэг ажээ.

Полиграф төхөөрөмж нь зориулалт, технологийн шийдэл зэргээс хамаарч ийнхүү янз бүр байх бөгөөд гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх өнөөгийн практикт ашиглах шаардлага, шинжлэх ухаан, технологийн дэвшил, хүний хүчин зүйл, эдийн засаг, санхүүгийн боломж зэргийг харгалзан үзээд, таваас цөөнгүй үзүүлэлтээр бичлэг хийх полиграф төхөөрөмжийг Монгол Улсад ашиглах нь илүү оновчтой, үр өгөөжтэй хэмээн бид тооцоолж байна.

Энэ төхөөрөмж нь амьсгалын хоёр, арьсны цахилгаан дамжуулах хариу урвал, судасны лугшилт, багтаамжийн фото бичлэг (фотоплетизмограмм) гэсэн таван сувгийн үзүүлэлтээр бүртгэл хийх боломжийг олгодог бөгөөд үүнийг ийнхүү журамлах нь полиграфологийн техникийн шинжлэх ухааны үндсийг өөрийн орны гэмт хэрэгтэй тэмцэх практикт оновчтой бүрдүүлэх, арга зүйн хүрээний зарим асуудлыг шийдвэрлэх, тухайлбал, техникийн стандарт тогтоох, технологийн горимыг ягштал мөрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Полиграф зүйн сэтгэц судлал ба физиологийн шинжлэх ухааны үндэслэл.

Полиграф зүйг гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх практикт оновчтой, үр дүнтэй ашиглахад түүний сэтгэц судлал, физиологийн шинжлэх ухааны үндэслэлийг зайлшгүй танин мэдэх шаардлагатай.

Хүний үйл ажиллагаа нь түүний мэдрэлийн тогтолцоо, сэтгэц физиологийн ажиллагаатай нягт холбоотой. Мэдрэлийн тогтолцоог бүтцийн хувьд төв мэдрэлийн болон захын мэдрэлийн гэж ангилдаг бөгөөд түүнийг дотор нь соматик ба вегетатив гэж авч үздэг. Мэдрэлийн соматик тогтолцоо нь булчингийн ухамсартай хөдөлгөөнийг (нүүрний булчингийн хөдөлгөөн, хүний биеийн идэвхтэй хөдөлгөөн гэх мэт), харин мэдрэлийн вегетатив тогтолцоо нь гөлгөр булчингийн ухамсартай бус хөдөлгөөнийг (дотоод шүүрлийн булчирхай, зүрх, арьс зэрэг) зохицуулан удирдаж байдаг.²⁵⁵

Мэдрэлийн вегетатив тогтолцоогоор зохицуулагддаг бие организмын хэсэг ухамсартай хяналтад тэр бүр захирагддаггүй. Дорно дахины йог болон орчин цагийн сэтгэц заслын техникийг эзэмшсэн тохиолдолд хүн судасны лугшилт, артерын даралт, амьсгалын давтамж ба хэмнэл зэрэг ухамсарт бус хөдөлгөөнөө удирдаж болно гэж ойлгогдохоор байдаг. Гэхдээ ердийн хүн бие эрхтний дотоод үйл ажиллагаагаа тэр бүр удирдаад байж чаддаггүй.²⁵⁶

²⁵⁵ 26 дахь тал.

²⁵⁵ Г.Дашзэвэг, Г.Батмөнх нар. Хүний физиологи. УБ., 2003. 89 дэх тал.

²⁵⁶ Хэссет Дж. Введение в психофизиологию. /Пер. с англ. И.И. Полетаевой. /Под ред. Е.Н. Соколова. М., Мир, 1981. С. 26.

Хүний биед гадаад орчны янз бүрийн нөлөө үйлчлэх үед хариу үйлдэл болж сэтгэл хөдлөл (эмоци) үүсдэг. Энэ нь тархины бүтцийн тодорхой хэсгүүдийн үйл ажиллагаатай холбоотой. Сэтгэл хөдлөл бол бие эрхтний физиологи төлөв бөгөөд гуниг зовлонгоос авахуулаад баяр хөөрийн дээд хэлбэр хүртэл мэдрэмжийн бүхий л хурц субъектив өнгийг агуулдаг.

Сэтгэл хөдлөлийн субъектив зовиур, сэтгэл хөдлөлийн илрэл гэсэн хоёр үзүүлэлтийг сэтгэл хөдлөлийн бүтцэд багтааж үздэг ба организм дахь соматик ба вегетатив өөрчлөлт энэ зовиураар илэрдэг. Сэтгэцийн бусад процессоос сэтгэл хөдлөл чухамдаа дотоод эрхтний ажиллагаатай холбоотойгоороо ялгагддаг.²⁵⁷

Сэтгэл хөдлөл нь тархины бүтцийн тодорхой хэсгүүдийн үйл ажиллагаатай холбоотой гэсэн нэлээд цэгцтэй онолын үзэл баримтлалыг анх Америкийн невропатологич Ж.Пейпец үндэслэжээ. Тэр сэтгэл хөдлөлийн үед тархины түргэн цуцалт (субстрат) үүсгэдэг тархины бүтцийн нэгдмэл системийн талаар таамаглал дэвшүүлжээ.²⁵⁸

Бие махбодийн дотоод орчин, үйлдэл төрх, сэтгэл хөдлөлийг удирддаг төв нь гипоталамус юм. Гипоталамусын бөөмүүдийг урд, хойт, дунд гэж байрлалаар нь хуваадаг ба түүний хөгжил 13-14 насанд гүйцдэг. Энэ үед гипоталамус-өнчин тархи хоорондын мэдрэл- шингэний холбоос бүрэн гүйцэд бий болно.

Гипоталамус нь үнэрийн тархи, суурийн зангилаа, таламус, гипокамп, их тархины чамархайн болон зулайн хэсэгтэй маш хүчтэй афферент холбоотой тул тархины бүтцийн бараг бүх хэсгийн байдлын талаар мэдээлэл хүлээн авдаг. Үүний зэрэгцээ, гипоталамус нь таламус, торлог байгууламж, нугас, тархины баганы вегетатив төвүүдэд мэдээлэл илгээж, гипоталамус нь бие махбодид олон чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Үүнд:

1. Вегетатив тохируулгыг удирдах төв болно. Гипоталамусын урд талын бүлэг бөөм цочроход бие махбодийн нөөцийг хадгалан, сэргээх парасимпатик үйл ажиллагаа идэвхждэг. Харин арын бүлэг бөөмийг цочрооход симпатик үйл ажиллагаанууд, тухайлбал, хүүхэн хараа өргөсөх, цусны даралт ихсэх, зүрхний цохилт олшрох, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн дарангуйлагдах зэрэг үйл ажиллагаа идэвхждэг.

2. Гипоталамус нь их бие, вегетатив, дотоод шүүрлийн үйл ажиллагааг нэгтгэн зангидах төв болдог. Иймээс ч гипоталамуст бие махбодийн дотоод орчны, биеийн дулааны, өлсөх, цангахын, бэлгийн зан үйлийн, сэтгэл хөдлөлийн, дур хүслийн, унтах-сэрүүн байх мөчлөгийн тохируулгын төвүүд байдаг.

²⁵⁷ Данилова Н. Н., Крылова А. Л. Физиология высшей нервной деятельности: Учебник. М.: Изд-во Московского ун-та, 1989. С. 263-264.

²⁵⁸ Мөн тэнд. 263-264 дэх тал.

3. Гипоталамусын урд талын бүлэг нейрон гипофизын урд хэсгийн аденогипофизын идэвхийг тохируулах даавар болох либерин, статин ялгаруулдаг.

4. Гипоталамусын дунд хэсгийн бүлэг нейрон цусны температурын өөрчлөлт, цахилгаан- соронзон хэлбэлзэл, сийвэнгийн осмос даралт, цусны дааврын найрлага, хэмжээг мэдрэн тохируулах үүрэгтэй.

5. Гипоталамусын арын бүлэг нейрон идэвхжихэд бодисын солилцоо эрчимжиж, зүрхний цохилт олширч, булчин чичирч, бие махбодийн дулаан үүсэлтийг нэмэгдүүлдэг. Харин урд хэсгийн бөөмүүд цочроход судас өргөсч, амьсгал түргэсч, хөлс ялгарч, дулаан алдалт нэмэгддэг.²⁵⁹

Хүний ухамсартай ба ухамсаргүй хөдөлгөөнийг тохируулах, түүний уялдааг хангах вегетатив үйл ажиллагаа ба үйлдэл төрхийн зохицуулгад уураг тархины нэгдмэл бүтцийн нэг болох бага тархи голлох үүрэгтэй.

Бага тархинаас нугасанд ирж буй мэдээлэл булчингийн агшилтын хүчийг тохируулж, булчин удаан хугацаагаар чангарах боломж олгож, тайван болон хөдөлгөөний үед булчингийн чангарлыг тохируулж, ухамсартай хөдөлгөөний хэмжээг тааруулж, нугалах, тэнийлгэх хөдөлгөөн нэг нь нөгөөдөө хурдан шилжих бололцоо олгодог.

Бага тархи нь бэлэн болсон хөдөлгөөний мэдээллийг хүлээн авч, их тархины гадаргыг энэ хөдөлгөөнийг бэлтгэх төлөвлөгөөтэй уялдуулж, уг хөдөлгөөнийг нугасаар дамжуулан хэрэгжүүлэхэд булчингийн чангарлыг бэлтгэж өгдөг.

Бага тархийг цочрооход бие махбодийн симпатик урвал идэвхжиж, харин гэмтээхэд үүний эсрэг урвал (парасимпатик) илэрдэг. Ийнхүү бага тархи бие махбодийн хөдөлгөөний, мэдрэхүйн вегетатив үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Энэ үйл ажиллагааг бага тархи мэдрэлийн тогтолцооны бусад хэсэгтэй хамтран хэрэгжүүлж байгаа хэдий ч эдгээр хэсгийн хамтын тохиромжтой үйлийг тохируулагчийн үүргийг бага тархи гүйцэтгэдэг.²⁶⁰

Сэтгэл хөдлөлийн сэтгэц физиологийн илэрхийллийг бэхжүүлэн авах буюу бодитоор хэмжиж болно. Сэтгэл хөдлөлийн байдал нь биеийн болон нүүрний булчингийн хөдөлгөөн, дохио зангаа зэрэг соматик хүрээний, арьсны цахилгаан идэвхжил, артерын даралт, амьсгал, судасны цохилт зэрэг вегетатив хүрээний өөрчлөлтийг бий болгодог.

Полиграф төхөөрөмжийн тусламжтайгаар хүний биеийн сэтгэц физиологийн дараах үзүүлэлтийг бүртгэж болно. Үүнд:

а) Арьсны цахилгаан дамжуулах чадвар. Хүний сэтгэц физиологийн байдал тодорхой шалтгааны улмаас өөрчлөгдөхөд арьсны цахилгаан дамжуулах чадвар болон мэдрэг чанар нь хувьсдаг бөгөөд

²⁵⁹ Г.Дашзэвэг, Г.Батмөнх нар. Хүний физиологи. УБ., 2003. 89 дэх тал.

²⁶⁰ Мөн тэнд. 89—91 дэх тал.

үүнийг арьсны гальваник урвалын үзүүлэлт хэмээн нэрлэдэг.

Хүний биеийн арьсан гадаргуу дахь дулааны тохируулгын тогтолцооны, тухайлбал хөлсний булчирхайн идэвхжлээр арьсны цахилгаан дамжуулах чадвар илт дээшилдэг байна. Ийм булчирхайн тоо хүний биед харилцан адилгүй байх тул биеийн хэсгүүдийн булчирхайн идэвхжил хүн бүрт өөр өөрөөр илэрнэ. Зарим хүмүүст ийм булчирхай цөөн тоотой байдаг тул тэдгээрийн арьсны цахилгаан дамжуулах чадвар болон мэдрэг чанарыг полиграф төхөөрөмж ашиглан тодорхойлох боломжгүй.

Арьсны цахилгаан дамжуулах чадвар болон түүний мэдрэг чанарыг гол төлөв хуруун дээр суурилуулах хос электродын тусламжтайгаар бүртгэж авдаг. Сэтгэл хөдөлгөхүйц асуулт асуух үед сэтгэц физиологийн шинжтэй хариу урвал явагдах бөгөөд энэ нь хөлс дааварлах, захын тараагуур судас өргөсөх зэргээр илэрнэ.

Полиграф ашиглах үед арьсны цахилгаан дамжуулах чадвар мэдээллийн хамгийн үнэтэй үзүүлэлт болдог бөгөөд худлыг 92% хүртэл илчилж чадна. Худал хариулах шийдвэр гаргаж буй үед арьсны гальваник урвал хамгийн ихээр илэрдэг байна.²⁶¹

Гэхдээ практикт яг үүний эсрэг үзүүлэлт бүртгэгдэх тохиолдол байдгийг анхааралдаа авах хэрэгтэй. Ач холбогдол бүхий асуултад хариулах үед зарим хүний арьсны цахилгаан дамжуулах чадвар сул илэрч буй нь ажиглагддаг. Үүнийг тухайн субъектын хариу үйлдлийн хэлбэрээр тайлбарлаж болох бөгөөд ярилцаж эхлэх үед хяналтын сорил явуулахад энэ байдал тогтоогдож болно. Зарим тохиолдолд арьсны цахилгаан дамжуулах чадвар илт багасч, амьсгал, судасны цохилт, багтаамжийн фото бичлэг (фотоплетизмограмм) зэрэг бусад үзүүлэлт өсч, үүнээс болж тухайн асуултын дундаж стресс үзүүлэлт нийлбэрээрээ бусад асуултынхаас хэзээд өндөр гарах нь бий.

Ярилцлагад оролцогч ядраагүй байх үедээ хариулж байгаа сорилын эхлэл хэсэгт арьсны цахилгаан дамжуулах чадвар буурдаг. Ийм тохиолдол нь хэт олон асуултад субъект ядарснаас үүдэлтэйгээр арьсны цахилгаан дамжуулах чадвар буурдаг үзэгдлээс ялгаатай. Өөрөөр хэлбэл, нөхцөлт бус цочроогчоор батжуулаагүй нөхцөлт рефлекс замрах шинжийг агуулдаг нь физиологийн шинжлэх ухаанд нэгэнт тодорхой тул арьсны цахилгаан дамжуулах чадварын үзүүлэлтээр үүнийг баримжаалахад нэлээд төвөгтэй гэсэн үг. Иймд ярилцагчид стандартын бус арьсны цахилгаан дамжуулах чадвар илэрвэл бусад сувгуудын хэмжүүрээр бүртгэж авсан үзүүлэлтэд голлон анхаарал хандуулах шаардлагатай.

б) Амьсгал- полиграф төхөөрөмж ашиглан ярилцах үед уламжлал болгон бүртгэж авдаг сэтгэц-бие махбодийн нэгэн үзүүлэлт. Хүний бие организмд байнга явагдах исэлдүүлэх үйл явцад ялгарах энергигүйгээр амьдрах боломжгүй бөгөөд чухам үүний үр дүнд зүрх ажиллаж, булчингууд агшиж, сэтгэн бодох үйл ажиллагаа явагдана. Энэ бүх үйл явц эсийн түвшинд явагдах ба эсийн үйл ажиллагаа хүчилтөрөгчийн хэрэгцээ, нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг шаарддаг. Хүчилтөрөгчийг эсэд хүргэх нүүрс хүчлийн хийг гадагшлуулах үүргийг хүний бие организмээр гүйж буй цус гүйцэтгэнэ. Цус нь уушигнаас хүчилтөрөгчийг авч, түүнийг био эд эсэд хүргэх, мөн уушгинд хуримтлагдсан нүүрс хүчлийн хийг гадагшлуулах нэг төрлийн тээврийн систем юм. Бие, сэтгэцийн аливаа хямралын байдал нь организмын нөөцийг дайчлах бөгөөд сэтгэл хөдлөлийн хүч их байх тусам хүчилтөрөгчийн зарцуулалт, нүүрс хүчлийн хийн ялгаруулалт ихэсдэг байна.

Амьсгалд илрэх аливаа өөрчлөлт, эсвэл хазайлт нь худлын хариу урвал байдаг. Ийм өөрчлөлтөд: амьсгал түргэсэх, илүү гүн амьсгалах, амьсгалаа богино хугацаагаар түгжих, хэмгүй (жигд бус) амьсгалах, амьсгалаа буруу хуваарилах (амьсгал авах ба гаргах харьцаа алдагдах), нэг бүтэн амьсгалахад амьсгал авах хугацаа гаргахаасаа урт байх зэрэг хамаарна.

Амьсгалах хоёр хэлбэр бий: дээд буюу цээжний амьсгал эмэгтэйчүүдэд гол төлөв илэрдэг бол доод буюу хэвлийн амьсгал эрчүүдэд зонхилж илэрнэ. Аливаа хүнд амьсгалын энэ хоёр хэлбэрийн аль нэг нь илэрнэ. Зарим эмэгтэйн амьсгалын хэмнэл жигд бус байх боловч түүнийг стрессээр тайлбарлаж болно.²⁶²

Амьсгалыг полиграфтай шууд холбосон уушигны бичлэг хийгчээр (пневмограф) хос, битүү гуурсны тусламжтайгаар хэмждэг. Сунаж, агшдаг ийм хос гуурсыг оролцогч хүний гэдэс, цээжинд байрлуулна. Амьсгал мэдрэгчийг хослуулан хэрэглэдэг нь ийм аргаар ярилцах үед бодит үр дүнд хүрэх зорилгыг илүүтэй хангадаг бөгөөд энэ нь хариу үйлдлийг гуйвуулж, хиймлээр өөрчлөх боломжийг хүндрүүлдэг.

в) Зүрх-судасны тогтолцоо. Зүрхний агшилт, судасны лугшилтыг эрт цагаас эхлэн хүний сэтгэл хөдлөлийн байдлыг тодорхойлоход ашиглаж иржээ. Гэмт хэрэгтний мэдрэл, сэтгэхүйн байдал артерын даралтад хэрхэн нөлөөлдөг болохыг Италийн криминологич Чезаре Ломброзо анхлан судалжээ.

Бие, сэтгэцийн аливаа хямралын байдал нь хүний зүрх, судасны тогтолцоонд эрс нөлөөлдөг бөгөөд

²⁶¹ Симонов П. В. Высшая нервная деятельность человека: Мотивационно-эмоциональные аспекты. / АН СССР. Институт высшей нервной деятельности и нейрофизиологии. М.: Наука, 1975. С.129.

²⁶² Benussi V. Die Atmungssymptome der Lüge //Archiv für die gesamte Psychologie. 1914. Bd. 316 S.244-273; Хэссет Дж. Введение в психофизиологию. /Пер. с англ. И.И. Полетаевой. /Под ред. Е.Н. Соколова. М., Мир, 1981. С. 26.; Рейковский Я. Экспериментальная психология эмоций /пер. с польского В.К. Вилюнаса /Под ред. О.В. Овчинниковой. М.: Прогресс, 1979. С. 315.

энэ нь артерын даралт огцом өсөх, зүрхний лугших хэм алдагдах, судасны цохилт түргэсэх хэлбэрээр илэрнэ.²⁶³

Артерын даралт гэдэг нь захын тараагуур судаснуудад цус эсэргүүцэлтэй тулгарах үед артерын судсанд үүсч бий болдог хүч. Зүрх агших үед энэ даралт дээд цэгтээ хүрдэг бөгөөд түүнийг агшилтын даралт, харин тэлэх үед хамгийн доод цэгтээ хүрдгийг тэлэлтийн даралт гэж нэрлэнэ.²⁶⁴

Полиграф аргаар ярилцах үед цусны харьцангуй даралтыг бүртгэж үнэлгээ өгнө. Хэмжих хэрэгслийн заалт мөнгөн усны баганы 60–70 мм-т хүрэх үе дэх үл мэдэг өөрчлөлтийг үндэслэн асуусан асуултад субъектын бие организм хариу урвал үзүүлж байгааг бүртгэж авна. Даралтыг хэмжих явцад гарын булчин хөөх зэргээр зарим нэг зовиур үүссэнтэй холбоотойгоор артерын даралтад өөрчлөлт орж болохыг анхаарах ёстой.

Артерын даралт хэмжих үед нөлөө бүхий цочроогчийг үзүүлсний дараа даралт бага зэрэг болон тогтвортой өөрчлөгдөж байгаа бол энэ нь бие организм урвал үзүүлж, сэтгэл хөдөлж буйн дохио юм. Зүрхний лугших давтамж хэмжигч (ЗЛД), зүрхний цахилгаан бичлэг (кардиограмм) (ЗЦБ), артерын цохилт (судасны лугшилт) тоологч зэрэг нь полиграф төхөөрөмжөөр бүртгэж байгаа сэтгэл хөөрлийн нэг л физиологи үзүүлэлтийг өөр өөрөөр харуулагч хэрэгсэл болдог.

Зүрхний цахилгаан бичлэг гэж зүрхний булчингийн агшихтай (зүрхний идэвх) холбоотой биоцахилгаан процессыг тусгасан бичлэгийг хэлнэ.²⁶⁵

Жирийн үед зүрхний лугших давтамж харьцангуй тогтвортой байдаг. Нөлөө бүхий цочроогчийг гаргаж тавихад амьсгал удааширахтай нэгэн зэрэг судасны цохилт удааширч, улмаар ЗЛД ихэсдэг. Энэ үед зүрхний лугших хэм цаашид ч тогтворжихгүй байж болно. Судасны үелзэл болон судасны үелзлийн давтамж бол зүрх лугшихад түүнээс орж ирсэн цусны даралттай холбоотойгоор артерын хананд үүсэх тогтмол хэмтэй хэлбэлзэл.²⁶⁶

г) Багтаамж бичүүр (Плетизмограф). Хүний биед агуулж буй цусны хэмжээ өөрчлөгдсөнөөр мөч, эрхтнүүдийн багтаамжид гарах өөрчлөлтийг багтаамжийн бичлэг (плетизмограмм) тусган харуулдаг.

Орчин үед цусны оптик шинжийг ашиглан цусан дахь цахилгаан гүйдлийг хуруугаар дамжуулан хэмжихдээ багтаамжийн фото бичлэгийг (плетизмограммыг) (БФБ) гол төлөв хэрэглэж байна.

Ингэхийн тулд хурууны өндгийг (эсвэл чихний гэдсийг) өчүүхэн жижиг гэрлээр нэвт тусгаад түүний эсрэг талд гэрэл мэдрэгч төхөөрөмж байрлуулна. Өндгөн дэх цусны хэмжээнээс шалтгаалан гэрлийн туяаны өнгө өөрчлөгддөг. Цусны хэмжээ ихэсхэд арьсны нягтрал ихэсч, түүгээр гэрэл бага нэвтэрнэ.²⁶⁷

Багтаамжийн бичлэгийн анализын үед хэлбэлзлийн далайц, хамрах талбайн хэмжээ гэсэн хоёр үзүүлэлтийг хэмждэг. Хэлбэлзлийн далайц гэж БФБ-ийг харуулсан дүрслэл дээр бичигч хэрэгслийн хошуу хазайхдаа гаргасан захын цэгүүдийг хэлдэг. Хамрах талбай гэж хошууны үзүүр хоёр тийш хамгийн их хазайсан шугамаар үүссэн талбайг хэлнэ. Их хэмжээгээр өдөөгч цочроогчийг гарган үзүүлэх үед энэ далайц, хамрах талбай болон муруйн хэлбэр өөрчлөгддөг.

Компьютерийн полиграф дээр суваг бүрийн бүртгэн авч байгаа мэдээллийг тусгай үзүүлэлтээр илэрхийлдэг бөгөөд энэ нь компьютерт суурилуулсан програм хангамжийн онцлогоос ихээхэн хамааралтай. Компьютерийн полиграф төхөөрөмж, програм хангамж үйлдвэрлэдэг фирмүүд ийм үзүүлэлтийг чухам ямар томъёоллоор гаргаж авдгаа нууцалдаг бөгөөд ингэснээрээ полиграф төрөөрөмж ашиглан хийсэн ярилцлагын үр дүнгийн нотлох ач холбогдлын үнэ цэнийг бууруулдаг.

Асуулгын явцад бүртгэж буй сэтгэц физиологийн өөрчлөлтүүдийг суваг тус бүрээр нь, нийлбэр үзүүлэлтээр нь бэхжүүлэн авах бөгөөд энэ тохиолдолд үзүүлэлтийн өөрчлөлтийн арифметик дундаж болгож ашигласан бүх сувгийн нийлбэрийг тооцно гэсэн үг. Үзүүлэлтийн өөрчлөлтийг дэвсгэр үзүүлэлтэд харьцах процентын харьцаа болон суваг тус бүрийн дотоод дахь дундаж үзүүлэлтэд процентоор харьцуулан авч үзнэ. Нэг суваг доторх үзүүлэлтийн өөрчлөлт ердийн дэвсгэр түвшингээс 20 нэгжээс багагүй байвал үүнийг сэтгэц хямралын мэдэгдэхүйц шинж гэж ойлгоно. Харин бүх сувгийн нийлбэр үзүүлэлт ердийн дэвсгэр түвшингээс 5–10 хувь өссөн байвал үүнийг сэтгэц хямралын өөрчлөлт ажиглагдаж байна гэж үзнэ.

Полиграф ашиглах хууль зүйн шинжлэх ухааны үндэслэл.

Полиграфологийн мэдлэгийг өнөөдөр гол төлөв гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх практикт өргөн ашиглаж байна. Энэ утгаараа полиграфологи нь криминалистикийн шинжлэх ухаантай нягт холбоотой бөгөөд түүний криминалистикийн онол, криминалистикийн техник зүй, криминалистикийн тактик зүй, криминалистикийн арга зүйн салбарт бий болсон мөрдлөг, зөвлөмж, онолын үзэл баримтлал нь полиграфыг гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагааны явцад ашиглах шинжлэх ухааны хөрс суурь нь болно. Тийм ч учраас техникийн тусламжтайгаар гэмт хэргийн холбогдолтой, сэтгэц

²⁶³ Русалова М.Н. Экспериментальное исследование эмоциональных реакций человека /АН СССР. Институт высшей нервной деятельности и нейрофизиологии. М.: Наука, 1979. С.84.

²⁶⁴ Словарь физиологических терминов. АН СССР. Отделение физиологии. Всесоюзное физиологическое общество. М.: Наука, 1970. С.117.

²⁶⁵ Мөн тэнд. 117 дахь тал.

²⁶⁶ Русалова М. Н. Дурьдсан бүтээл. 93 дахь тал.

²⁶⁷ Хэссет Дж. Введение в психофизиологию. /Пер. с англ. И.И. Полетаевой. /Под ред. Е.Н. Соколова. М., Мир, 1981. С. 91.

физиологийн үүсэлтэй мэдээлэл цуглуулах арга, барил, хэрэгслийг судалдаг мэдлэгийн салбарыг “криминалистикийн полиграфологи” гэж нэрлэн хөгжүүлж байна.

Криминалистикийн полиграф зүйн мөн чанарыг хууль зүйн доктор Б.Бат-Эрдэнэ: «Үгэн өдөөгчийн нөлөөгөөр сэжигтний биеийн сэтгэл зүй, физиологийн үзүүлэлт өөрчлөгдөх, тухайлбал, хөлс ялгарах, зүрхний цохилт хурдсах, удааширах, цусны даралт ихсэх, буурах, булчин агших, ам хатах, биеийн дулаан нэмэгдэх, арьс улайх, нүдний хүүхэн хараа томрох зэргийг багажийн тусламжтай бүртгэж, дүн шинжилгээ хийхэд оршино» гэж үзжээ.²⁶⁸

Полиграф зүйн мэдлэг нь криминологийн шинжлэх ухаантай нягт уялдаатай бөгөөд гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүнийг судалдаг мэдлэгийн салбарын хувьд криминологийн боловсруулсан зөвлөмж, мөрдлөг нь полиграфын арга зүйд шийдвэрлэх ач холбогдолтой.

Гэмт хэрэгтнийг танин мэдэх, үүний үндсэн дээр тухайн этгээдийн криминологи шинжийг тодорхойлох арга зүйг полиграф төхөөрөмж ашиглах үед зайлшгүй харгалзаж үзэх ёстой.

Гэмт явдлын онол, гэмт явдлын шалтгааны онол, гэмт хэрэгтэн бие хүний онол зэрэг криминологийн шинжлэх ухааны хүрээнд бий болсон үзэл баримтлал нь полиграфологийн мэдлэгийг гэмт хэрэг илрүүлэх практикт амжилттай хэрэглэх чухал хөшүүрэг болно.

Полиграфологийн мэдлэг нь хууль зүйн сэтгэц судлалтай нягт холбоотой ба хуульч бие хүн, түүний үйл ажиллагааны агуулга, сэтгэц зүй, гэмт хэрэгтний сэтгэц зүйн онцлог, эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны онцлогийг судалдаг мэдлэгийн тогтолцооны хувьд тухайн хавсарга шинжлэх ухааны хүрээнд хуримтлагдсан мэдлэг нь гэмт хэрэгтэн бие хүний сэтгэц зүйн онцлогийг танин мэдэх боломж олгоно.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан²⁶⁹ хууль зүйн практик ажиллагааг сэтгэц зүйн өвөрмөц мэдлэгээр зэвсэглэх, тухайлбал, шүүх сэтгэц гэм судлалын онол, арга зүйг боловсруулах, хууль хэрэглэх үйл ажиллагаанд сэтгэл зүйч мэргэжилтнийг оролцуулах арга замыг тодорхойлох асуудлыг хууль зүйн сэтгэл судлалын тодорхой зорилтуудын нэг гэж үзсэн бөгөөд хууль зүйн сэтгэл судлалын ерөнхий зүй тогтолтой холбоотой нийтлэг зорилтуудын зэрэгцээ хууль зүйн тодорхой ажиллагааны хэрэгцээгээр нөхцөлдсөн цаг үеийн тусгай зорилтууд дэвшигдэн гарч ирэх боломжтой гэж үзсэн байдаг.

Бидний үзэж байгаагаар, полиграфологийн мэдлэгийг Монголын хууль сахиулах практикт нэн даруй нэвтрүүлэх, идэвхтэй ашиглаж эхлэх нь тулгамдсан зорилтын нэг болон тавигдаж байна.

Полиграфологийг гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхөд ашиглах эрх зүйн зохицуулалтын асуудал өнөөдөр эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинжлэх ухааны өмнө тулгамдаж байна.

Эрүүгийн хэргийг мөрдөх явцад бодит үнэнийг тогтоохын тулд хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь судлах эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тусгай зарчим байдаг. Уг зарчмын мөн чанар нь шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь эрүүгийн хэргийн бүх нөхцөл байдлыг тал бүрээс нь, бүрэн бодитой судлахын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авах үүрэгтэй байдагт оршино.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах явцад хэргийг тал бүрээс нь судална гэдэг бас сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, түүнд хүлээлгэх хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх бүхий л байдлыг тогтооно гэсэн хэрэг мөн. Бүх талыг хамарч шинжилгээ судалгаа явуулах зайлшгүй нөхцөл нь эрүүгийн хэрэг дээр ажиллагаа явуулахдаа хэргийн байдлаас урган гарсан бүхий л зүйл, тухайлбал, гэмт хэргийн арга, хэргийг үйлдсэн байж болох хүн, гэмт хэргийн сэдэлт, шалтгаан зэрэгт хамаарах аливаа таамаглалыг шалгах явдал юм.²⁷⁰

Эдгээр таамаглалыг шалгаж, бодит үнэнийг тогтоож чадах, олон улсын практикаар нэгэнт туршигдаж батлагдсан аргын нэг бол полиграф мөн хэдий ч полиграф ашиглан олж авсан мэдээллийг нотлох баримт болгон ашиглах асуудал өнөөдөр маргаантай хэвээр байна.

Хэрэв аливаа баримт сэлт, мэдээлэл нь:

Нэгдүгээрт, зөвхөн гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх баримт сэлт, мэдээлэл байх ёстой;

Хоёрдугаарт, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэлээр олж авсан байх ёстой;

Гуравдугаарт, энэ нь зохих үндэслэлээс гадна хуульд заасан журмын дагуу цуглуулсан байх ёстой гэж үзвэл полиграф аргыг эрүүгийн процессын ажиллагаанд ашиглах эрх зүйн орчин ямар нэгэн хэмжээгээр бүрдсэн гэж ойлгож болохоор байна.

Сүүлийн жилүүдэд гадаадын улс орнуудын хууль сахиулах байгууллагын практикт, тухайлбал, ОХУ-д Полиграф зөвхөн шуурхай-эрэн сурвалжлах ажлын (гүйцэтгэх ажлын) чиглэлээр бус, түүнчлэн нотлох баримт цуглуулах зорилгоор полиграф төхөөрөмж ашиглан, шүүх-сэтгэц физиологийн шинжилгээ хийх хэлбэрээр өргөн ашиглаж эхлээд байна.

Полиграфологийн мэдлэгийн салбар анхлан шинжлэх ухаан, технологийн өндөр хөгжил бүхий улс орнуудад, тухайлбал, АНУ, Франц, ХБНГУ-д үүсч хөгжсөнтэй холбоотойгоор өнөөдөр дэлхийн ихэнх улсын тусгай албад, эдгээр орны мэргэжилтнүүдийн боловсруулсан арга зүй, тоног төхөөрөмжийг ашиглаж байна.

Сэтгэц физиологийн үзүүлэлтүүд, ялангуяа, цочроогчид үзүүлэх хариу урвал үндэстэн бүрийн

²⁶⁸ Б.Бат-Эрдэнэ. Криминалистик (Лекцүүд). УБ., 2003. 105-106 дахь тал.

²⁶⁹ С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ., 2005. 105 дахь тал.

²⁷⁰ Б.Бат-Эрдэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2004. 70 дахь тал.

тухайд өөр өөр байж болох, мөн зарим нэгэн онцлогийг агуулж болох тухай шинжлэх ухааны таамаглалыг бид өөрсдийн судалгаанд түшиглэн дэвшүүлж байна. Хэрэв энэхүү таамаглал бодитой байна гэж үзвэл, дээрх улс орнуудад боловсруулсан арга зүйн зарим мөрдлөг, зөвлөмжийг өөрийн орны нөхцөлд эргэж авч үзэх шаардлагатай болно. Энэхүү таамаглалыг бид үндэстэн, ястнуудад мэдрэл сэтгэцийн давамгайлах хэв шинж илрэх, зан араншин, темперамент өөр өөр байх үзэгдэлтэй холбон авч үзэж байна.

Бидний судалгаанаас үзэхэд, полиграфологийн ойлголтыг задлан шинжлэх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг тайлбарлах явцад полиграфологийн онол, практикийн тулгамдсан тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дараах онолын мөрдлөг, гаргалгааг хийж болохоор байна. Үүнд:

1. Полиграфологийн мэдлэгийн салбарт түгээмэл хэрэглэдэг ойлголт, нэр томъёо зэргийг цэгцлэх, хууль зүй, сэтгэц судлал, эрүүл мэнд, техникийн шинжлэх ухааны үүднээс тэдгээрийг нэг мөр ойлгох, онол-практикийн хүрээний тодорхой асуудлыг оновчтой томъёолох, цаашид уг мэдлэгийн тогтолцоог бүхэлд нь хөгжүүлэх зорилгоор “Полиграфологи”, “полиграфын сорил зүй”, “полиграфын онош зүй”, “полиграфын мэдээлэл зүй”, “полиграфын арга зүй”, “полиграфын тактик зүй”, “полиграфын шинжилгээ зүй” зэрэг шинжлэх ухааны агууламж бүхий олон ухагдахууныг бий болгон тодорхойлох шаардлагатай.

2. Полиграфологийн шинжлэх ухааны ерөнхий үндэслэл, түүний техникийн болон сэтгэц судлал, физиологийн шинжлэх ухааны үндэслэл, түүнчлэн хууль зүйн шинжлэх ухааны үндэслэл, онолын үзэл баримтлалыг сайтар судалж, өөрийн орны хууль зүйн практикт нэвтрүүлэн, мэргэжилтэн, судлаачдын хүртээл болгох асуудал тулгамдаж байна.

3. Полиграфын оношилгоо зүйн орчинд илрэх Монгол хүний сэтгэц физиологийн онцлогийг нээн гаргах, түүнийг танин мэдэх шаардлага урган гарч байгаа бөгөөд энэ чиглэлээр бий болох мэдлэг нь полиграфын арга зүйг боловсронгуй болгон хөгжүүлэх, түүний найдвартай байдлыг дээшлүүлэхэд ихээхэн үр нөлөөтэй болох нь тогтоогдож байна.

4. Полиграфын арга зүйн үрөгөөжийг дээшлүүлэхэд полиграфын тоног төхөөрөмж, програм хангамж ихээхэн нөлөөтэй бөгөөд эдгээрийг өөрийн орны гэмт хэрэг илрүүлэх практикт нэвтрүүлэхдээ түүний шинжлэх ухааны үндэслэл, техникийн боломж, чадавх зэргийг нь харгалзан үзвэл зохино.

5. Полиграфологийн салбарт ажиллах үндэсний мэргэжилтэнг тусгайлан бэлтгэх шаардлагатай ба тэдгээр нь хууль зүй, сэтгэц, физиологи, техникийн мэдлэгийн салбарт зохих боловсрол эзэмшсэн байвал зохино.

6. Хууль сахиулахын их сургуульд үндэсний мэргэжилтэн бэлтгэх эхлэл тавих нь зүйтэй.